



III БҮЛЭГ: ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

| | |
|--|--|
| Тавигдах шаардлага: | <ul style="list-style-type: none"> • Одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох норм дүрмийг баримтлан сүүлийн үеийн дэвшилтэт техник технологийг ашиглан үйлчилгээ үзүүлэх. • Хууль зүйн яамнаас олгосон харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр гэрчилгээтэй байх. • Дохиолол хамгаалалтын үйлчилгээ эрхэлэх тусгай зөвшөөрөлтэй байх. • Яаралтай үед ажиллах шуурхай бүлэгтэй байна. • Шуурхай бүлгийн болон мэргэшсэн харуул хамгаалалтын хүний нөөцтэй байх • Шуурхай бүлгийн 3-с доошгүй 24 цагийн эргүүлийн машинтай байх, машин тус бүр тусгай дуут дохионы зөвшөөрөлтэй байх |
| Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад баримт: | <ol style="list-style-type: none"> 1. Захиалагч болон нийлүүлэгчийн ажлын даалгаварыг харьцуулсан байдлаар дэлгэрэнгүй танилцуулга, фотог хүснэгтээр бэлтгэж баталгаажуулан ирүүлнэ. 2. Үйлчилгээний үнийн задаргаа ба үйлчилгээ үзүүлэх хуваарийг баталгаажуулан ирүүлнэ. 3. Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанаарын шаардлага хангасан үйлчилгээг захиалагчид үзүүлэх баталгааг албан бичгээр гаргаж ирүүлнэ. 4. Үйлчилгээ нь тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл, заалтыг орхигдуулсан, зөрсөн боловч захиалагчийн тогтоосон шаардлагыг үндсэнд нь хангаж байгааг нотолсон мэдэгдлийг баталгаажуулан ирүүлнэ. 5. Байгууллагын дэлгэрэнгүй танилцуулга ирүүлнэ. 6. Стандарт шаардлагад нийцсэн өөрийн хяналтын байртай болохыг нотолсон гэрчилгээ, фото зураг, түрээсээр ашигладаг бол түрээсийн гэрээг ирүүлнэ. 7. Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээллэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг ирүүлнэ. 8. Харилцагч банк болон эрх бүхий бусад холбогдох байгууллагуудаас тендертэй холбоотой асуудлаар тодруулга авахад татгалзах зүйлгүй тухай албан мэдэгдэл ирүүлнэ. 9. Ажил гүйцэтгэх явцад гэрээнд заагдсан эрсдлийг бүрэн хариуцаж ажиллах тухай албан бичиг ирүүлнэ. 10. Дээрх шаардсан баримт бичгүүдээс аль нэгийг ирүүлээгүй эсвэл тод гаргацгүй, ойлгомжгүй, зөрүүтэй ирүүлсэн тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно. |

Үйлчилгээ үзүүлэх хүний нөөц: “Шаардана”

| д/д | Албан тушаал | Хүний тоо | Мэргэжил | Туршлага |
|-----|----------------------------|-------------------|-----------------------|----------|
| 1 | Дохиолол хяналтын оператор | 4 ба түүнээс дээш | Мэргэжил харгалзахгүй | - |

| | | | | |
|---|--|-----------------------|--|------------------------|
| 2 | Шуурхай бүлгийн Харуул хамгаалалтын ажилтан | 12 ба түүнээс дээш | Энэ чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдсан мэргэшлийн гэрчилгээтэй байх | 1 буюу түүнээс дээш |
| 3 | Харуул хамгаалалтын ажилтан | 3 - 4 | Энэ чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдсан мэргэшлийн гэрчилгээтэй байх | 1 буюу түүнээс дээш |

- Инженер техникийн ажилчдын жагсаалтыг МАЯГТ 7, 10 -т заасны дагуу бөглөж ирүүлнэ. (Сургууль төгссөн дипломын хуулбарыг ирүүлэх шаардлагагүй ба Төрийн мэдээлэл солилцооны ХҮР системээр дамжуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгана)

- Төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia- д инженер, техникийн ажилтнуудын дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг лавлах шаардлагатай бөгөөд дээрх мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн бол тендерийн нээлтээс өмнө БШУЯ-ны Мэдээллийн технологи статистикийн хэлтэст хандаж дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгүүлнэ үү. Дээрх бүртгэл хийгдээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу.

- Ажилтан тус бүрээр мэргэжлийн үнэмлэхний хуулбар, иргэний үнэмлэхний хуулбар ирүүлнэ. Төрийн үйлчилгээний цахим машин буюу ТҮЦ машинаас авсан нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолтыг эх хувиар (тухайн ажилтны ажлын туршлагад заасан жилүүд)-ийн хамт ирүүлнэ. (Үндсэн ажилтны ажлын туршлага, ажилласан жилийг ТҮЦ машины тодорхойлолтоор тус тус нотлоно. ТҮЦ машины тодорхойлолтын баар кодыг тод гаргацтай ирүүлнэ. Мэргэжлийн туслах ажилчид ТҮЦ машины ажилласан жилийн лавлагаа ирүүлэх шаардлагагүй. Лавлагаа ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.

- Тухайн инженер, техникийн ажилтны ажилд томилогдсон тушаалын хуулбарыг ирүүлнэ.

- Санал болгож буй албан хаагч тус бүрийг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан тухай нотлох баримт ирүүлнэ.

Үйлчилгээ үзүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: “Шаардана”

| Д/д | Машин механизмын тоног төхөөрөмжийн нэр, зориулалт | Тоо ширхэг | Өөрийн эзэмшил эсхүл Түрээс |
|-----|--|-------------------|-----------------------------------|
| 1 | 24 цагийн шуурхай дуудлагын машин | 3 ба түүнээс дээш | Компанийн эзэмшилийн эсхүл түрээс |
| 2 | Шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж | Иж бурдэл | Фото зураг ирүүлнэ. |
| 3 | Стандарт дүрэмт хувцас | Иж бурдэл | Фото зураг ирүүлнэ. |

- Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмуудын жагсаалтыг холбогдох мэдээлэл хамт ирүүлнэ. Шуурхай бүлгийн тээврийн хэрэгслийд нь бүрэн тоноглогдсон, “шар гэрэл” дохиоллын зөвшөөрөлтэй байх. Нийт машин механизмын тоног төхөөрөмжүүдийн фото зургийг ирүүлнэ.
- Дээрх машин механизмын эзэмшигчийн талаарх мэдээллийг Төрийн мэдээлэл солилцооны ХҮР системээр дамжуулан шалгана.

Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага: “Шаардана”